

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД
АУДИТ, ХЯНАЛТ ШАЛТГАЛТЫН ТАЙЛАН
/ТОВЧЛОЛ/

2019 оны 8 дугаар сарын 16-ны өдөр

Баянхонгор сум

ИНЕГ-ын даргын баталсан 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 19/18 дугаар “ИНЕГ-ын харьяа Баянхонгор аймаг дахь нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай удирдамж”-ын хүрээнд 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдрийг дуусталх хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаанд дотоод

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны аудитор П.Цогбаяр, санхүүгийн мэргэжилтэн Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудит, хяналт шалгалтыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, нэгжийн даргын гаргасан тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, хүний нөөц бүрдүүлэлт, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт, худалдан авалт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгалаа.

1. Нисэх буудлын аюулгүй байдлын шалгагч Т.Сарангэрэлд Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчиж 2-5 хоногийн чөлөөг 2019 онд 3 удаа олгосон байна
2. ИНЕГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 5.1.1-д “ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжид ажлын өдөр 08.00 цагт эхэлж, 17.00 цагт дуусна” гэж заасан боловч тус аймгийн нисэх буудал нь ажлын өдөр 09.00 цагт эхэлж, 18.00 цагт дуусч байгаа нь дээрх журмыг зөрчсөн байна.
3. 2018 онд ажилчдад ээлжийн амралтыг олгохдоо Нисэх буудлын захиргаанаас тухайн ажилтныг хэд хоног амрах, хэзээ амраад хэзээ орохыг тодорхой заасан холбогдох ажилтны гарын үсэг бүхий ээлжийн амралтын хуудас олгодоггүй байсан бол 2019 онд олгож эхэлсэн боловч холбогдох ажилтны гарын үсэг, тамга тэмдэггүй байна.
4. Нисэх буудлын даргын гаргасан тушаал шийдвэрүүд нь “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-т тавигдсан шаардлагууд болох баримт бичгийн утга санааг бүрэн зөв илэрхийлсэн байх, товч тодорхой, ойлгомжтой, логик дэс дараалалтай байх, үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаа мадаггүй байх зэрэг шаардлагуудыг зөрчсөн.
5. Ажилчдад үр дүнгийн нэмэгдэл хөлс олгохдоо “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6.2.5.1-д “Ажилтанд тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан бол сахилгын шийтгэл ногдуулсан сард ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохгүй.” гэсэн заалтыг зөрчсөн.
6. Зарим гүйлгээний нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.
7. ИНЕГ-ын даргын “Хөдөлмөрийн хөлсний сүлжээг шинэчлэн батлах тухай” 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/410 дугаар тушаалын дагуу ажиллагсдын 05 дугаар сарын цалинг тооцож өмнөх сарын зөрүүг нэмж олгохдоо цалингийн нэмэгдлийг дутуу олгосон байна.
8. Ажиллагсдын ээлжийн амралтын олговрыг тооцож олгохдоо өмнөх ээлжийн амралтын олговрыг дундаж цалингийн тооцоонд оруулж тооцсоноор ажилтнуудад ээлжийн амралтын олговрыг илүү олгосон байна.
9. Ажиллагсдын иргэний нисэхийн салбарт удаан жил ажилласны нэмэгдэл хөлс, жилийн эцсийн үр дүнгийн урамшуулалыг олгохдоо үндсэн баримтыг сайтар судлаагүй буруу тооцож олгосон.
10. Байгууллагын архив байрлаж буй өрөөний чийг дулааныг тогтмол хянаж тэмдэглэл хийгээгүй.



11. Тус нисэх буудлын 2018-2019 онд байгуулсан гэрээнд огноо тавиагүй, дугаарлаагүй мөн гэрээг байгуулсан байгууллагуудын удирдах албан тушаалтнууд батлаагүй.
12. Нисэх буудлын ажиллагсад албан томилолтоор ажиллахдаа удирдамж батлуулж ажиллаагүй байна.
13. Тус нисэх буудалд хадгалагдаж байгаа ТС-1 түлшний үлдэгдэлд тооллого хийж үзэхэд байвал зохих үлдэгдлээс 671.5 кг-аар илүү байна.
14. Шилэн дансны цахим хуудасны хөтлөлттэй холбоотой хугацаа хоцроох, хөрөнгө мөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрийг байршуулаагүй зэрэг зөрчил байна.
15. Шалгалтаар илэрсэн ажиллагсдын хөдөлмөр цалин хөлсний тооцоогоор илүү, дутуу олгосон зөрчил илэрсэн.

Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг засаж залруулах талаар тус нисэх буудалд 16 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА